

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ Н.БАДАМЧИМЭГИЙН
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

I Төлөвшил

1.Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

Сурагчдыг бусдыг хүндэтгэн харилцдаг, гэр бүл, найз нөхдөө хайрлан тусалж дэмждэг, биеэ зөв авч явдаг, ёс заншил, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг зөв дадал хэвшил, төлөвшилтэй болгох зорилгоор:

- ❖ БИ МОНГОЛ ХҮҮХЭД сэдэвт Бүтээлийн уралдааныг ангидаа зохион байгуулж, сургуульдаа бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.
- ❖ Сургуулийн цахим номын сантай танилцаж, уншлага хийлээ.
- ❖ Урлаг наадам, Хэлний наадам, баримлын бүтээл, “Алтан намар” наамал, “Миний аз жаргалтай өдөр”, “Миний эргэн тойрон-Миний эрх” зургийн уралдаанууд, “Би монгол хүүхэд” бүтээлийн уралдаануудад, математик, монгол хэлний олимпиадад идэвхтэй оролцсон.
- ❖ Эрүүл мэндийн хичээлээр эмч ээжтэй хамтран бэлгийн ариун цэврийн талаар сурагчдад мэдээлэл, зөвлөмж өглөө.
- ❖ “Нэг сурагч-нэг ном” аянд нэгдэн сургуулийнхаа цахим номын санд сурагч бүр ном хандивлалаа.
- ❖ “Миний эргэн тойрон – миний эрх” аяны хүрээнд ангидаа хэлэлцүүлэгт хичээл зохон байгуулж сурагчидтай санаа бодлоо солилцлоо.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал

- ❖ Дэг баримталж сурснаар юуг яаж хийх ёстойгоо ойлгож өөрийн үйл ажиллагаагаа хэвшмэл болгож чадлаа.Үүнд: Үдийн цай уухын өмнө гараа цэвэрлэх, хоол цайгаа идээд аяга тавгаа цэвэрлэж хураах, хичээллэх үеийн дэгийг баримталснаар хичээлийн идэвх оролцоо сайжирсан.
- ❖ Хичээлийн оролт, таралт дээр ангийн хаягаа барьж жагсан гарч хэвшлээ.
- ❖ Ангийн жижүүр хийхдээ сурагч бүр хуваарийн дагуу үүргээ гүйцэтгэж сурлаа.
- ❖ Салаа салаагаараа ангийн их цэвэрлэгээг долоо хоног бүр хийж хэвшлээ.
- ❖ Дүрэмт хувцас, биеийн тамирын хувцсаа журмын дагуу зөв өмсөж, биеэ зөв авч явахад суралцаж, эмх цэгцтэй байлгахад суралцаж байна. Дүрэмт хувцсаа логожуулж ,биеийн тамирын хичээлд орохдоо формоо сольж эвхэж хурааж сурч байна.
- ❖ Сурагч бүр гэрийн даалгавраа тогтмол гүйцэтгэхдээ бие биедээ шаардлага тавьснаар сурагчид гэрийн даалгаврын гүйцэтгэл нэмэгдэж, тогтмол хийж хэвшиж байна.
- ❖ Хүний эрхийн өдрийн тохиолдуулан “Миний эрх” сэдэвт хичээлийг орсноор хүүхэд бүр эрх, үүргийн талаарх ойлголтыг авч өөрийн эрх үүргийг ухамсарлаж байна.
- ❖ Сурагч бүр өдөр тутмын амны хөндийн эрүүл ахуйг сахихад суралцав.

3. Бусадтай харилцах зан чанар:

- ❖ Ангийн андууд болон сургуулийн багш ажилчидтай эерэг хүндлэлтэй зөөлөн харилцаж сурлаа. Баярласан талархснаа байнга илэрхийлж Баярлалаа гэдэг үгийг хэлж хэвшив.
- ❖ Ангийн хурлыг хийж зүй бус үг хэллэг хэрэглэн бусдыг доромжилдог, дэг журам баримталдаггүй сурагчдыг авч хэлэлцэн анхааруулга өгөн алдаа дутагдлаа засах талаар ярилцлаа.
- ❖ Бие биедээ урмын үг хэлэх, мэндлэх хүндлэх ёсонд суралцлаа.
- ❖ Ангийнхаа найзуудтайгаа зөв харилцаж, бусдыгаа сонсох, санаагаа зүй зохистой илэрхийлэхэд суралцаж байна.
- ❖

4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал

- ❖ Бусдад өөрийн санаа бодлоо илэрхийлж байна.
- ❖ Сонирхсон зүйлээ бусдаас асуух, эрэл хайгуул хийж сонирхон хийж байна.
- ❖ Хүн ба байгаль хичээлээр туршилт, ажиглалт хийх чадвараа хөгжүүллээ.
- ❖ Дугуйлан секцэд хамрагдаж өөрийн авьяас чадвараа хөгжүүлсэн.

5. Жижүүр багшийн үнэлгээ

2018 – 2019 оны хичээлийн жилд сар бүр хуваарийн дагуу жижүүр багшийн үүрэгт ажлыг гүйцэтгэн үнэлэлт дүгнэлт хийлгэлээ. Үнэлгээ маш сайн байсан.

6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал

Энэ хичээлийн жилд дараах судалгаануудыг авч сурагчдаа оношлон ажилласан.

- ❖ Сурагчдын сонирхолын судалгаа \ сонирхлын судалгааны үр дүнд ангийн сурагчдын 48%-ийг дугуйлан секцэд хамрууллаа. \
- ❖ Гэрийн даалгаврын судалгаа
- ❖ Зорчих хөдөлгөөний судалгаа \ судалгааг авснаар сурагчдын гэрээс сургуульд ирэх хугацаа болон сургуулиас харих хугацааг тооцоолсноор сурагчдад өгөх гэрийн даалгаврын хэмжээ, гүйцэтгэлд бас дүн шинжилгээ хийх боломжтойг ажиглалаа. \
- ❖ Айдсын судалгаа \ энэхүү судалгаагаар сурагчдын айдас нь юунаас үүдэлтэй, хэрхэн айдсаа даван туулах талаар ярилцлага өрнүүллээ. \
- ❖ Гэр бүлийн судалгаа \ энэхүү судалгаа нь сурагчдын гэр бүл дэх байр суурь, хэм хэмжээг мэдэх, хэн хэнтэйгээ амьдарч ямар зан үйлд суралцдаг, хэнээс хичээл номоо асуудаг зэрэг олон мэдээллүүдийг мэдэж авсан. \
- ❖ Гар утасны хэрэглээ боломж, цахим хэрэглээний судалгаа.
- ❖ Сурагчдын “ТЕСТ” ажилбарт хийсэн судалгаа.

7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

Энэ хичээлийн жилд Эцэг эхчүүдээ 4 баг болгон ангийн ажлын зохион байгуулан ажиллав. Ангийн орчны тохижилт аюулгүй эрсдэлгүй орчныг бүрдүүлж ангийн самбарын байршлыг сольсноор сурагч бүр бүрэн сайн самбараа харах боломжийг олголоо. Мөн 7 хоног бүрийн баасан гарагт их цэвэрлэгээ хийж эрүүл мэндэд нь анхаарлаа. Мөн аюулгүй байдлыг

нь хангах зорилгоор сурагчдын ширээг хулдаасаар бүрж, ангийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн. Эцэг эхтэй хамтран эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулав.

8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт

- ❖ Хүүхэд хамгааллын тухай сургалтанд сууж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн баримталж эцэг эхэд таниуллаа.
- ❖ Гараас гарт эцэг эхийн гарын үсэг улирал бүр зуруулсан.
- ❖ Гараас гарт хөтөлбөрийг хэрэгжүүлэн сурагчдыг гараас гарт өгч ажиллав.

9. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт

- ❖ Суралцагчдын зан чанарын хувьд: Сургалтын бүхий л үйл ажиллагаагаар зөв зан чанар, зөв хандлага, зөв дадал хэвшилд суралцаж, хөгжүүлэх зорилго тавин ажиллаа.

II Мэдлэг чадвар ахиц, амжилт

- ❖ Гарааны болон Оношлох үнэлгээ
- ❖ Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалтыг MOODLE системд оруулан, жишиг даалгавар болон тестийн сан бүрдүүллээ.
- ❖ Хүүхэд бүрийн бичих чадварт анхаарч бэлтгэсэн сэдвээр цээж биичг авах, уншуулах, яриулах зээг ажлуудыг хийлээ.
- ❖ I ба II хагас жилийн мэдлэг чадварын сорилыг авч 8 түвшингээр үнэлэн анализ хийсэн.
- ❖ Сурагчдын гарааны үнэлгээг тогтоосон ба I,II улирлын эцсийн шалгалтаар ахиц, амжилтыг нь тооцож, сурагчдадаа алдаа оноог нь хэлж өгснөөр сурагчид өөрийн алдааг хянах түүнийгээ засах, сайжруулах эрмэлзлэлтэй болж байна.
- ❖ Багаар хамтран ажиллах, бусадтайгаа санаа бодлоо солилцож бусдаасаа суралцах, бусдыгаа урамшуулах зэрэг үйлийг хийснээр сурагчдын сурах үйл ажиллагааг идэвхжин, тэдний өөртөө итгэх итгэл, багаар ажиллах чадвар нв нэмэгдсэн байдлыг харгалзан үнэлгээ хийлээ.
- ❖ Тус хичээлийн жилд МХ- 26 нэгж, МАТЕ -16 нэгж, Хүн ба орчин 15 нэгж, Дүрслэх Урлаг 12 нэгж боловсруулан хагас жилээс хойших бүх нэгж хичээлээ MOODLE програмуу хийсэн.
- ❖ Стандарт хэрэгжилт маш сайн шалгагдав.

Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөгөө хийж баталгаажуулан ажиллаад дүгнэхэд 100% гүйцэтгэлтэй байна.

- ❖ Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн: Судлагдахуун тус бүрээр хөтөлбөр хийж, сургалтаа явуулсан. Үр дүн суралцагч тус бүр эзэмших мэдлэг чадвараа өөрийн түвшиндээ хүлээн авч эзэмшлээ.
- ❖ Журнал бичилт

Хичээлийн жилийн турш цаг хугацаанд нь журналаа бичиж, менежерээр баталгаажуулан дүгнүүлсэн. Менежерээс өгсөн үүрэг, зөвлөгөө аван бүрэн гүйцэт биелүүлсэн.

- ❖ Хичээлд ордог сурагчдын хүртээмж
- ❖ Нийт тасарсан цаг. 614 Үүнээс: тасалсан 28 цаг чөлөөтэй 145 цаг өвчтэй 441цаг

- ❖ Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт
Бүтэн жилийн турш хөтөлж менежерээр хянуулсан байна.
- ❖ Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил
- ❖ Ангидаа “Зургийн” уралдаан, “Үсэглэлийн хаад”, “Хурдан уншигч”, “Хурдан бодогч”, “Цэвэр бичигтэн” уралдаанудыг зохион байгуулснаар сурагч бүр хичээнгүй, анхааралтай бодлх, унших чадварт суралцлаа.
- ❖ Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал
 - Эцэг эхтэй хамтран ажиллаж шийдвэрлэдэг.
 - Багш ганцаарчлан сурагчтай ярилцах, зөвлөгөө өгнө.
 - Сургалтын явцад тулгамдаж буй асуудалд үргэлж тусалдаг.

III Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

Сурагчдыг ном унших хүсэл тэмүүлэлтэй болгох, танин мэдэхүй, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, урлан бүтээх чадвар, авьяасыг нээн хөгжүүлэх зорилгоор:

- ❖ Сурагч бүрээс сонихлын суадлгааг авч эцэг эхэд танилцуулснаар эцэг эх хүүхдийнхээ сонирхлын дагуу хөгжих тал дээр тусламж дэмжлэг үзүүлсэн.
- ❖ Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа /танхим ба танхимын бус/
Танхимын бус дугуйланд 20 сурагч суралцдаг. Үүнд: шатар 3, хийл 2, бокс 2, усан бассейнд 4, бүжиг 5, уран хайчилбар 1, англи хэл 1, жудо 1, теаквандо 2, агаарын теннис 1, гольф 1 гэх мэт.

Танхимын IQ дугуйланд 19 суралцагч суралцаж хөгжлөө.

- ❖ Ангийн номын сангийн баяжилт
Ангиараа “Цахим номын сан” –даа хүүхэд бүр 1ширхэг нийт 60 ш ном бэлэглэсэн.

Ангидаа сайн дураараа ном цуглуулан баяжилт хийлээ.

- ❖ Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх
Уншсан номын тэмдэглэл хөтөлж мөн номныхоо танилцуулгыг хийж сурсан. Үүнд: зохиогч, он сар, гол дүр, туслах дүр, агуулгыг зургаар илэрхийлэхээс гадна зохиолоос юуг ойлгож ухаарч авснаа бусдадаа хуваалцаж сурлаа

- ❖ Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал
Сургуулийн 2 давхарт 2 удаа, ангидаа 14 хоног бүр сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж сурталчилсан.

- ❖ Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль/

№	Сурагчийн нэр	Хугацаа	Тэмцээн уралдааны нэр	Амжилт
1	Б.Нарангүнж	2018-9 сар	МХОрдоны бүжиг	Авьяаслаг сурагч алтан медаль
2	Д.Дөлгөөн	2018-12 сар	Авьяаслаг 23 урлаг наадам	Гоцлол бүжиг алтан медаль
3	Р.Төгөлдөр	2019 – 3 сар	САШ шатрын тэмцээн	“Уран нүүдэлт сурагч” алтан медаль
4	Хч.Сарнай	2019 – 5 сар	Солонгос хэлний олимпиад	Зохион бичлэгээр 2-р байр
5	Р.Төгөлдөр	2019 – 5сар	Кенгуру ОУ олимпиад	2-р зэргийн диплом
6	М.Уранмарал	2019 – 5сар	Кенгуру ОУ олимпиад	3-р зэргийн диплом

7	Б.Анхзаяа	2019 – 5сар	Кенгуру ОУ олимпиад	3-р зэргийн диплом
	Анги хамт олон	2018 – 12 сар	Урлаг наадам	1-р байр

Бүтээлч ажил:

Ангид эрүүл мэндийн буланг хөөсөнцрөөр хийн байрлуулж сурагчдада эрүүл мэндийн мэдээллийг хүргэж байна.

Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал

- Скаутын сургалтыг 14 хоногт 1 удаа хийж бүлгийн хичээлээр зааж сурагчдаа хөгжүүлэв.
- Монгол хэлний цагаар марафон уншлага хийж сурагчдын анхаарал, унших хурдыг нэмэгдүүллээ.

Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- Тус хичээлийн жилд MOODLE программийн сургалтанд сууж “Батламж”-аа авлаа.
- Судлагдахуун тус бүрийн хөтөлбөр ээлжит хичээлүүдийг Moodle системд орууллаа.
- Илтгэлийн уралдаануудад амжилттай оролцлоо. Үдүүрэгт 2-р байр, нийслэлд дэд байр эзэлсэн. \
- “Нэг баг нэг арга зүй” уралдаанд амжилттай оролцлоо.
- STEM боловсролын хэлэлцүүлэгт хичээлд оролцлоо.
- Бусад багш нарынхаа хичээлд сууж арга зүйн туршлага судаллаа.

IV Боловсролын сэтгэл ханамж

❖ Цаг ашиглалт

Хичээлийн жилийн 31 долоо хоногийн сургалтын үйл ажиллагаанд хоцорч хожигдож чөлөө аваагүй, таслаагүй ажлаа хийжээ. \ 7 хоногийн акттай байлаа.\

❖ Сэтгэл ханамжийн судалгааны

Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааг Эцэг эхийн нээлттэй хаалганы өдрөөр авч нэгтгэн өглөө. Сэтгэл ханамж сайн үнэлгээтэй байна. Гуравласан гэрээ байгуулан ажиллав. School police- эргүүлийг бүх эцэг эхчүүд хийж үүргээ биелүүлэв.

❖ Хичээлийн цагийн хариуцлага - 40 минут

Судлагдахуун тус бүрийн хичээлийн 40 минутыг хариуцлагатай сайн заалаа. Цахим хичээл 12 заагдсан. Өдөр бүр хичээлийн 40 минутанд хийсэн зүйлийг шалган тайлбарлаж, нэгж хичээлийн төгсгөлд шалгуурын дагуу шалган анализ дүгнэлт хийж ажиллав.

❖ Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт

Ямар нэг зөрчил гараагүй болно.

- ❖ Багшийн хичээлийн бэлтгэл
Судлагдахуун тус бүрийн Багшийн ном зөвлөмжийг уншиж, сургалтандаа хэрэглэлээ. Интернет орчноос хэрэгтэй зүйлийг татаж ашигласан.
- ❖ Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн
Тус ангид хичээлээ тасалдаг хүүхэд байхгүй. Хичээл хоцролт маш бага.
- ❖ Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал
Багшийн журнал, Анги удирдсан багшийн журнал, багшийн дэвтрийг зохих журмын дагуу сургалтын менежерээс зөвлөгөө аван, заавар зөвлөгөөний дагуу бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь бүрэн хөтлөн шалгуулсан байна.
- ❖ Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал
Сургалтын үйл ажиллагаандаа техник хэрэгслийг тогтмол ашигладаг.
- ❖ Сурагчдын хөгжил төлөвшил, эрсдэлийн судалгааны сан бүрдэлт
Ангийн сурагчдын социометрийн судалгаа: сайн найз, дээрэлхдэг сурагч, найзлахыг хүсдэг, хажууд нь суухыг хүсдэг чиглэлээр авлаа.
- ❖ Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал
Хяналтын хуудасны хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж дараагийн ажилдаа мөрдлөг болон ажиллав.

V Эрүүл мэнд

- ❖ Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа

Дэгийн дагуу сурагчид багш ахмад хүмүүстэй байнга мэндэлдэг. Мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэж сурлаа.

- ❖ Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

Сурагчдаас эрүүл ахуйн хэрэгсэлтэй эсэх судалгаа авлаа. Үүнд: Хувцасны даавуун уут, аяганы даавуун уут, аяганы доод алчуур, гар ариутгагч, пүүзний уут гэх мэт. Ангидаа эмийн сантай болсноор бусдад анхны тусламж үзүүлж сурлаа.

- ❖ Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн

-Эрүүл ахуйч эмчтэй уулзалт зохион байгуулсан.

- Сурагчдад гар ба шүдээ зөв угаах видео бичлэгийг үзүүлэн дадал хэвшил болгох зөвлөгөө өгсөн.

- ❖ Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал

Сурагчид хуваарийн дагуу жижүүр хийж сурсан. 7 хоногийн баасан гараг бүрт салаа салаагаараа хуваарийн дагуу ангид их цэвэрлэгээг тогтмол хийж сурсан.

- ❖ Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал

Ангидаа маш цэвэр цэмцгэр суудаг. Их цэвэрлэгээ хийсэн. Эрүүл ахуйн хэрэгслийг шалган тогтмол хэрэглэж сурлаа.

- ❖ Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх

-Сурагчид өдөр бүр 4,4-өөрөө жижүүрийн үүрэгт ажлаа сайн хийж хэвшсэн.

- Үдийн цайны орчинг бүрдүүлэх, сурагч бүр орчноо цэвэрлэх,

Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал

Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгснөөр эвдрэлгүй байж эд хогшилтой зөв харьцаж сурсан.

- ❖ Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал:
 - Сургуулийн эмчтэй хамтран сурагчдын биеийн жин, өндрийн судалгааг хичээлийн жилийн эхэн ба төгсгөлд авч хүүхдийн өсөлт хөгжлийг эцэг эхчүүдэд танилцуулсан.
 - Витаминжуулах аяныг жил бүрийн 11-12 дүгээр сард зохион байгуулдаг.
 - 4-р цагийн завсарлаагааны цагаар алжаал тайлах дасгалыг хийж хэвшлээ.
 - Сурагчид томуу болон томуу төст өвчин түүнээс урьдчилан сэргийлэх мэдээлэл боловсруулж бие биедээ зөвлөгөө өгсөн.
- ❖ Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
Ангидаа эрүүл мэндийн булантай түүгээрээ дамжуулан сурагчдад мэдлэг мэдээллийг байнга өгч байдаг.
- ❖ Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил:
 - Сурагчдад гар ба шүдээ зөв угаах видео бичлэгийг үзүүлэн дадал хэвшил болгох зөвлөгөө өгсөн.
 - амны эрүүл ахуй сэдэвт хичээлийг орсноор сурагчид эрүүл шүдний ач тусыг мэдэж авлаа.
- ❖ Сургуулийн эмчийн үзлэгээр орж, эцэг эхэд танилцуулсан байна.

Дүгнэлт

2018 – 2019 оны хичээлийн жилд 4г анги нь 64 сурагчтайгаар хичээллэлээ. Энэ хичээлийн жилд 19 сурагчтайгаар IQ дугуйланг хийчээллэж ажилттай төгслөө. “Авьяаслаг -23” урлаг наадамд 1-р байранд шалгарч. Хамтлаг бүжиг, гоцлол бүжгийн төрлүүдэд “Шилдэг үзүүлбэр”-ийн эзэд боллоо.

Улирал бүр сурагчдынхаа хичээлийн ахиц амжилтыг дээшлүүлж, хувцсаа бүрэн өмсөх, үдийн цайгаа зөв уух, алжаал тайлах дасгал хий зэрэг дадал хэвшилтэй болцгоолоо. Мөн долоо хоног бүрийн хичээлийг “МУ-ын төрийн дуулал”-аараа эхлүүлж хэвшлээ.

Багшийн хувьд 3 жилийн үндсэн сургалтандаа хамрагдлаа, БМДИ-ийн англи хэлний сургалт, MOODLE праграммын сургалтуудад амжилттай хамрагдаж өөрийгөө хөгжүүллээ. Мөн багш нарын илтгэлийн урадаанд дүүрэгт 2-р байранд шалгарч нийслэлийн илтгэлийн уралдаанд тусгай байрт шалгарсан амжилттай байлаа.

Анги дэвших сонгох шалгалтыг 75%, нэгдмэл агуулгын шалгалтыг 76% тус тус гүйцэтгэлтэйгээр шалгууллаа.

Тайлан бичсэн: бага боловсролын багш Н.Бадамчимэг

Хавсралт

STEM сургалт- Хэлэлцүүлэгт хичээл



Ц.Эрдэнэтуяа багштай 46 ангид заагдсан STEM-ын хэлэлцүүлэгт хичээлд сууж ий заах арга, ур чадварын туршлагаас суралцлаа.



Математик олимпиадаас амжилт гаргасан сурагчид



Чингэлтэй дүүргийн багш нарын дундах илтгэлийн уралдаанд Д.Нанжид багштай хамтран оролцож 2-р байранд шалгаран нийслэлийн илтгэлийн тэмцээнээс тусгай байранд шалгарлаа.



MOODLE-ийн сургалтанд цаг хугацаандаа хамрагдан судралцаж шалгалтаа 94% амжилттай өгч Батламжаа авлаа. Moodle системийг танилцуулах үйл ажиллагааг БАЗАН-аа төлөөлөн амжилттай гүйцэтгэлээ.



IQ дугуйланд 19 суралцагчийг хамруулан хичээллүүлснээс нийт 3 суралцагч математик олимпиадын шагнал хүртсэн амжилттай байна.



БМДИнститутийн “Англи хэл”-ний сургалт болон 3 жилийн үндсэн сургалтандаа хамрагдлаа.



Сургуулийн цахим номын санд сурагч бүр нэг ном хандивлалаа. Мөн уншлагын цагаараа ном уншлаа.



Сургууль, дүүргийн “Тамирчин багш” уралдаанд, Марафон- 2019-д амжилттай оролцлоо.



“Авъяаслаг – 23” урлаг наадамд анги хамт олноороо 1-р байранд шалгарлаа.

\ “Дэвүүрт охид” хамтлаг бүжиг, “Балет”-ын гоцлол бүжгийн төрлөөр тус бүр “Шилдэг үзүүлбэр” алтан медаль хүртсэн.\